

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Монголын Үндэсний Музей

2026 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ							
1.1.	Зорилт 1.1. Музейн үндсэн үйл ажиллагааны дүрэм, журмыг хууль, эрх зүйн орчинд нийцүүлэн шинэчлэх	0	Батлагдсан баримт бичгийн тоо	-	Музейн үндсэн үйл ажиллагааны дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж эрх бүхий этгээдээр батлуулсан байна.	Монголын Үндэсний музейн дүрэм, үзэл баримтлал, стратеги төлөвлөгөө, үзүүлэл дэглэлтийн төлөвлөгөө, хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг хууль эрх зүйн орчинд нийцүүлэн шинэчилж байна.	100%
1.1. 1	Монголын Үндэсний музейн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлуулж, улсын	0	1.Сайдын тушаалаар батлагдсан бүтэц, дүрэм 2.Улсын бүртгэлд бүртгүүлсэн эсэх	2025 онд Монголын Үндэсний музейн шинэ дүрэм, зохион байгуулалтын бүтцийн төслийг боловсруулж,	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: Монголын Үндэсний музейн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг	1.Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын Сайдын 2026 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 тушаалаар Монголын Үндэсний музейн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн баталсан. 2.Батлагдсан дүрэм, бүтцийг улсын бүртгэлд бүртгүүлсэн. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: Монголын	100%

	бүртгэлд бүртгүүлэх.			ССАЖЗЯ-нд хүргүүлсэн.	Сайдаар батлуулж, Улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Жилийн эцэст: 0	Үндэсний музейн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Сайдаар батлуулж, Улсын бүртгэлд бүртгүүлсэн. Хавсралт: 12 файл	
1.1. 2	Байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтэц шинэчлэн батлагдсантай уялдуулан Хөдөлмөрийн дотоод журам, Албан тушаалын тодорхойлолт, Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн батлуулах.	0	Баталсан баримт бичгийн тоо	-	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Жилийн эцэст: Захирлын тушаалаар Хөдөлмөрийн дотоод журам 1, албан тушаалын тодорхойлолт 36, хөдөлмөрийн гэрээ 56 нийт 93 баримт бичгийг шинэчлэн боловсруулж баталсан байна.	1. МҮМ-н захирлын 2026.01.30-ны өдрийн А/06 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээг боловсруулах ажлын хэсэг байгуулсан. 2. 2026.02.24-ний өдрийн А/12 дугаар тушаалаар албан тушаалын тодорхойлолтыг баталсан. 3. 2026.06.04- ний өдрийн А/53 дугаар тушаалаар Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан. 4. 2026 оны А/68 дугаар тушаалаар нийт ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээг байгуулаад байна. Хүрсэн түвшин: Жилийн эцэст: Захирлын тушаалаар Хөдөлмөрийн дотоод журам 1, албан тушаалын тодорхойлолт 36, хөдөлмөрийн гэрээ 56 нийт 93 баримт бичгийг шинэчлэн боловсруулж баталсан байна. Хавсралт: 3 файл	100%
1.1. 3	Байгууллагын стратеги төлөвлөгөө (2027-2030)-г боловсруулж батлуулах.	0	Сайдын тушаалаар батлагдсан стратеги төлөвлөгөө	Шинэ ажил	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Жилийн эцэст: Стратеги төлөвлөгөөг боловсруулж сайдын тушаалаар	1. Байгууллагын стратеги төлөвлөгөө (2027-2030)-ний анхны төслийн хувилбарыг музейн нэгжүүдэд өгч, ирсэн саналуудыг тусгаж стратеги төлөвлөгөөний төслийн эцсийн хувилбарыг бэлэн болгосон. 2. Төслийн эцсийн хувилбарыг Музейн эрдмийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	80%

					батлуулсан байна.	Хүрсэн түвшин: Жилийн эцэст: Стратеги төлөвлөгөөг боловсруулж сайдын тушаалаар батлуулсан байна.	
Хоёр. Төрийн үйлчилгээ, чанар хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ							
2.1.	Зорилт 2.1. Музейн байнгын ба түр үзэсгэлэнгийн танхимаар олон нийтэд үйлчилж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, үзэгчдийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөл, аюулгүй байдлыг хангах	0	-Үзэгчдийн тоо. -Нэг үзэгчээс олох дундаж орлогын хэмжээ	2025 онд 69,928 үзэгчдэд үйлчилсэн.	Музейн байнгын ба түр үзэсгэлэнгийн танхимаар олон нийтэд үйлчилж, үйлчилгээний чанар хүртээмж, үзэгчдийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөл, аюулгүй байдлыг сайжруулсан байна.	Музейн байнгын ба түр үзэсгэлэнгийн танхимын чанар хүртээмжийг сайжруулж, үзэгчдийн тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 6 арга хэмжээ хэрэгжүүлсэн.	90%
2.1.1	Байнгын болон түр үзэсгэлэнгийн танхимаар олон нийтэд үйлчлэх.	0	1. Үзэгчдийн тоо 2. Гадаад үзэгчдийн эзлэх хувь 3. Нэг үзэгчээс олох дундаж орлогын хэмжээ 4. Үзэгчдийн сэтгэл ханамжийн түвшин	2025 онд 69,928 үзэгчдэд үйлчилсэн.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 1.40.000 үзэгчдэд үйлчилсэн байна. 2.Гадаад үзэгчдийн эзлэх хувь 30%-иас доошгүй байна. 3.Үйлчлүүлэгчдийн сэтгэл	1. 2026 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар нийт 51.357 үзэгчид үйлчлүүлсэн байна. Үүнээс 2026.03.01-07-ны өдрүүдэд Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 96 дугаар тогтоол, ССАЖЗЯ-ны 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 15/527 дугаар албан бичиг, “Музейн нээлттэй өдрүүд - 2026” арга хэмжээний дагуу үнэ төлбөргүйгээр 33.012 үзэгчдэд үйлчилсэн. - Байнгын үзэсгэлэнгээр 18,354 үзэгч үйлчлүүлсэн. Үүнд: Гэр бүл-175 - (1%) Гэр бүлийн хүүхдийн тоо- 504-(2.7%) Дотоод том хүн (төлбөртэй) - 498 (2.7%)	100%

					ханамжийн судалгаа хийсэн байна. Жилийн эцэст: Жилийн эцэст: 1.Нийт 100.000 үзэгчдэд үйлчилж, үүнээс гадаад үзэгчдийн эзлэх хувь нь 55%-иас доошгүй байна. 2.Нэг үзэгчээс олох дундаж орлогыг 15,500 төгрөгт хүргэнэ. 3.Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг 80%-д хүргэнэ.	Гадаад жуулчин (төлбөртэй) - 9083 (49.5%) Оюутан (төлбөртэй) - 880 (4.8%) 0-16 хүртэлх хүүхэд - 5,929 (32.3%) Өндөр настан /тэтгэвэр/- 1,060 (5.8%) Хөгжлийн бэрхшээлтэй иргэд- 188 (1.0%) Үнэгүй гадаад зочид 37 (0.2%) Нийт: 18,354 (100.0%) 2. Гадаад үзэгчийн эзлэх хувь нь 49.5%, буюу 9,083 жуулчид эзэлж байна. 3. Нэг үзэгчээс олох дундаж орлогын хэмжээ: 11,482 төгрөг. 4. Санамсаргүй түүврийн аргаар 244 үзэгчээс бичгээр сэтгэл ханамжийн судалгаа авч 230 хүн (94.3%) музейн үйлчилгээ, үйл ажиллагааг "сайн" гэж үнэлсэн. Үүнээс 125, гадаад 105 үзэгч байна. 14 хүн (5.7%) музейн үйлчилгээ, үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй гэсэн үнэлгээ өгсөн. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: 1.40.000 үзэгчдэд үйлчилсэн байна. 2.Гадаад үзэгчдийн эзлэх хувь 30%-иас доошгүй байна. 3.Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийсэн. Хавсралт: 4 файл	
2.1. 2	Монголын Үндэсний музейн байнгын үзүүллэгийн танхимын дэглэлтийг шинэчлэн сайжруулах.	67.810.00 0 Нэмэлт орлого	Шинэчлэн дэглэсэн танхимын тоо	2025 онд 1 танхим шинэчилсэн.	Эхний хагас жилд: Жилийн эхэнд: Байнгын үзүүллэгийн 1 танхимын үзүүллэг дэглэлтийг шинэчилнэ. Жилийн эцэст: Жилийн эцэст: Байнгын үзүүллэгийн	Үзмэр, цуглуулгыг эргэлтэд оруулах, мэдлэг мэдээллийг оновчтой сурталчилж түгээх, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх зорилгоор байнгын үзүүллэгийн “Нэн эртний Монгол орон” танхимыг 45 м2 талбайгаар өргөжүүлж, 2 ширхэг үзмэрийг буулган Сан хөмрөгт шилжүүлэн байршуулж, Сан хөмрөгөөс 7 дэсийн 11 ширхэг үзмэрүүдийг гарган шинэчлэн дэглэсэн. Мөн дээрх үзмэрийн хаяг тайлбар, хүний үүсэл, чулуун зэвсгийн хөгжил, онцлогийг харуулсан тайлбарт	100%

					нийт танхимын үзүүлэг дэглэлтийг шинэчилсэн байна.	2 самбарыг бэлтгэн дэглэсэн. Хүрсэн түвшин: Байнгын үзүүлэгийн 1 танхимын үзүүлэг дэглэлтийг шинэчилсэн. Хавсралт: 8 файл	
2.1. 3	Музейн түр үзэсгэлэнгийн танхимыг өргөтгөн засварлаж, үйлчилгээний орчин нөхцөлийг сайжруулах.	45.000.00 0 Нэмэлт орлого	Өргөтгөн засварласан талбайн хэмжээ (м2).	Шинэ ажил	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: Түр үзэсгэлэнгийн танхим (320 м2)-ыг өргөжүүлж, засвар тохижилт хийнэ. Жилийн эцэст: -	Монголын Үндэсний музей нь 2000-иад оноос хойш түр үзэсгэлэнгийн 1 танхим буюу 110м2 талбайтай танхимаар үзэгчдэд үйлчилж байсан. 2026 онд түр үзэсгэлэнгийн танхимыг өргөтгөх, тохижуулах ажлыг хийж 110м талбайтай танхимыг өргөтгөн 210м2 бүхий зэргэлдээ танхимтай нь аркаар холбож засварын ажил хийж, одоо 2 танхим буюу нийт 320м2 талбайтай танхим болгон өргөтгөж, тохижилт хийж сан хөмрөгийн болон байгууллага хувь хүмүүсийн цуглуулгаар тусгай үзэсгэлэн дэглэн үзэгчдэд үйлчилж байна. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: Түр үзэсгэлэнгийн танхим (320 м2)-ыг өргөжүүлж, засвар тохижилт хийнэ. Хавсралт: 10 файл	100%
2.1. 5	Музейн үзүүлэгийн танхимд эйр кондишн суурилуулах.	15.883.36 0 Нэмэлт орлого	Шинээр суурилуулсан кондишны тоо	Музейн 7 танхим агааржуулалт ын системгүй.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: Үзүүлэгийн танхимд 2 эйр кондишн суурилуулна. Жилийн эцэст: -	1. Үзүүлэгийн танхимд тавих эйр кондишн суурилуулахаар судалгааг хийж, сонгон шалгаруулалт явуулсан. 2. "Цогт Күүл Энержинг" ХХК-тай ажил гүйцэтгүүлэхээр 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 25/0051 дугаартай гэрээг байгуулсан. 3. Монгол Улсын Ерөнхий сайдын 2026.04.08- ны өдрийн 05 дугаар албан даалгаврын дагуу нэмэлт санхүүжилтийн зарцуулалтын эрх нээгдээгүйн улмаас тус ажлын гүйцэтгэл түр хойшилсон.	80%

						Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: Үзүүлэгийн танхимд 2 эйр кондишн суурилуулна. Хавсралт: 1 файл	
2.1.6	Музейн интернэтийн дотоод сүлжээг шинэчлэн сайжруулж, байнгын болон түр үзэсгэлэнгийн танхимд интернэт ашиглах, мэдээлэл авах боломж бүрдүүлэх.	18.000.000 Нэмэлт орлого	Үзүүлэгийн танхимуудад интернет орчин бүрдүүлсэн эсэх.	Музейн үзэсгэлэнгийн танхимуудад интернет сүлжээ байхгүй.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: Музейн дотоод сүлжээг шинэчилж, үзүүлэгийн танхимуудад интернет орчин бүрдүүлнэ. Жилийн эцэст: -	Музейн дотоод сүлжээг шинэчилж, үзүүлэгийн танхимуудад интернет орчин бүрдүүлэн ажиллаж байна. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: Музейн дотоод сүлжээг шинэчилж, үзүүлэгийн танхимуудад интернет орчин бүрдүүлнэ. Хавсралт: 3 файл	100%
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
3.1.	Зорилт 3.1. Сан хөмрөгийг баяжуулж, үзмэр цуглуулгын бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх, сэргээн засварлалт хийлгүүлэх, хадгалалт хамгаалалтын орчин	332,520,600	Сан хөмрөгийн баяжилт, хадгалалт хамгаалалтын нөхцөл, бүртгэн баримтжуулалт, бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагааны тоон мэдээлэл	2025 онд зорилтын хүрээнд 2 арга хэмжээ хийж гүйцэтгэсэн.	Сан хөмрөгийн баяжилт, хадгалалт хамгаалалтын нөхцөл, бүртгэн баримтжуулалт, бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагаа сайжирсан байна.	Үзмэр цуглуулгын хадгалалт хамгаалалт, бүртгэл мэдээллийн сангийн үйл ажиллагааг сайжруулах, үзлэг хяналт тавих зорилго бүхий хагас жилийн төлөвлөгөөт ажлыг бүрэн гүйцэтгэсэн.	100%

	нөхцөлийг сайжруулах, үзлэг хяналт тавих.						
3.1.1	Сан хөмрөгийг баяжуулан, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөний тайлан мэдээг СӨҮТ-д хүргүүлж, сан хөмрөгийн хадгалалтын орчны дулаан, харьцангуй чийгшлийн багаж, жин хэмжүүрийг баталгаажуулж, гэрчилгээжүүлэх.	7,500,000	1. СӨҮТ-д хүргүүлсэн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөний тайлан (улирал тус бүрээр). 2. Шавж устгалын хор цацуулсан нийт талбайн хэмжээ. 3. Баталгаажуулж, гэрчилгээжүүлсэн дулаан, харьцангуй чийгшлийн багажийн тоо 4. Баталгаажуулж, гэрчилгээжүүлсэн жин хэмжүүрийн тоо.	- Жил бүр Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөний тайланг I-IV улирлаар гарган нэгтгэж СӨҮТ-д хүргүүлэн ажилладаг. - Жил бүр сан хөмрөгийн орчин нөхцөлийг сайжруулж, шавж устгалын хор цацуулж, хуваарийн дагуу цэвэрлүүлдэг. - Сан хөмрөгт ашиглагдаж буй нийт 36 ширхэг чийг дулаан хэмжигч багаж, Том жижиг нийт 5 жинг	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөний тайланг I-II улирлаар гарган нэгтгэж СӨҮТ-д хүргүүлсэн байна. 2. II улиралд бүх сан хөмрөгийн өрөө болон үзүүлэгийн танхимуудын нийт 1570 м2 талбайд шавж устгалын хор цацуулж, хуваарийн дагуу цэвэрлэгээ хийсэн байна. Жилийн эцэст: Жилийн эцэст: 3. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөний тайланг III-IV улирлаар гарган	1. Үзмэрийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор нийт 5 дэсийн 5 үзмэрийг удирдамжийн дагуу СӨҮТ-д хүргэн, сэргээн засварлуулж байна. 2.Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөний I-II улирлын тайланг нэгтгэж, СӨҮТ-д албан бичгээр болон цахимаар хүргүүлэн ажиллав. 3. Музейн үзмэр, эд өлгийн зүйлийг биологийн нөлөөллөөс хамгаалах, хадгалалтын хэвийн орчныг бүрдүүлэх зорилгоор “Халдваргүйжүүлэлт” ХХК-тай 2026.06.15-ны өдрийн 26/25 дугаартай гэрээ байгуулж, II улиралд бүх сан хөмрөгийн өрөө болон үзүүлэгийн танхимуудын нийт 1570 м2 талбайд шавж устгалын хор цацуулж, хуваарийн дагуу цэвэрлэгээ хийсэн. Хүрсэн түвшин: 1. Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн шилжилт хөдөлгөөний тайланг I-II улирлаар гарган нэгтгэж СӨҮТ-д хүргүүлсэн байна. 2. II улиралд бүх сан хөмрөгийн өрөө болон үзүүлэгийн танхимуудын нийт 1570 м2 талбайд шавж устгалын хор цацуулж, хуваарийн дагуу цэвэрлэгээ хийсэн байна. Хавсралт: 9 файл	100%

				мэргэжлийн байгууллагаар баталгаажуулсан гэрчилгээ авсан.	нэгтгэж СӨҮТ-д хүргүүлсэн байна. 4. IV улиралд 34 ш дулаан, харьцангуй чийгшлийн багаж, 6 жин хэмжүүрийг баталгаажуулж, гэрчилгээжүүлсэн байна. 5. IV улиралд бүх сан хөмрөгийн өрөө болон үзүүллэгийн танхимуудын нийт 1570 м2 талбайд шавж устгалын хор цацуулж, хуваарийн дагуу цэвэрлэгээ хийсэн байна.		
3.1.3	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг хийж, тайлагнах.	500,000 Төсөв	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогын тайлан.	4 жилд тутамд зохион байгуулагддаг.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 2025-2026 онд зохион байгуулагдсан улсын тооллогод хамрагдсан 20.489 дэсийн 56.066 ш үзмэрийн тайлан мэдээ гарган,	2025.09.22-2026.06.03-ны өдрүүдэд МҮМ-н 2025-2026 оны Түүх соёлын хөдлөх зүйлийн улсын тооллого хийж, 3,802,433,270.55 төгрөгийн үнэлгээ бүхий 20450 дэсийн 56022 ширхэг үзмэрүүдийг тоолж, Тоолов 2025, Тоолов 2026 тэмдэг дарж баталгаажуулсан. Хүрсэн түвшин: 2025-2026 онд зохион байгуулагдсан улсын тооллогод хамрагдсан 20.489 дэсийн 56.066 ш үзмэрийн тайлан мэдээ гарган, холбогдох байгууллагад хүргүүлнэ.	100%

					холбогдох байгууллагад хүргүүлнэ. Жилийн эцэст: -	Хавсралт: 10 файл	
3.2.	Зорилт 3.2. Музейн сан хөмрөг болон байгууллага, хувь хүмүүсийн цуглуулгаар гадаад, дотоодод бие даасан үзэсгэлэн дэглэх, хамтран зохион байгуулах, түүх, соёлын хөдлөх дурсгалыг олон нийтэд түгээн сурталчлах.	179,995,300 Нэмэлт орлого	Зохион байгуулсан үзэсгэлэнгийн тоо, Сурталчилгааны арга хэмжээ, бүтээлийн тоо	Жилд 6-аас доошгүй удаа үзэсгэлэн, эвент арга хэмжээ зохион байгуулдаг.	Бие даасан болон хамтарсан 11 үзэсгэлэн, олон улсын болон дотоодын соёлын арга хэмжээ зохион байгуулж, олон нийтэд толилуулсан байна.	Музейн сан хөмрөг болон байгууллага, хувь хүмүүсийн цуглуулгаар дотоодын 6 тусгай үзэсгэлэн зохион байгуулж, гадаадын 1 үзэсгэлэнд хамтран оролцож, соёлын өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажилласан.	100%
3.2.2	Байгууллага, хувь хүмүүсийн цуглуулгаар хамтарсан тусгай үзэсгэлэн зохион байгуулах.	50,350,000	1. Хамтарсан тусгай үзэсгэлэнгийн тоо. 2. Үзэгчдийн тоо 3. Үзэгчдийн сэтгэл ханамжийн түвшин	Жилд 6-аас доошгүй удаа үзэсгэлэн зохион байгуулдаг.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 1.Байгууллага, хувь хүмүүсийн цуглуулгаар хамтарсан 6 тусгай үзэсгэлэн зохион байгуулсан байна. 2.Үзэгчдийн	1.Байгууллага, хувь хүмүүстэй хамтарсан 6 үзэсгэлэн зохион байгуулж, 1 гадаад үзэсгэлэнд үзмэр оролцуулан хамтран ажиллаж, олон нийтэд сурталчлан ажилласан. Үүнд: 2026.01.01-02.15-нд: "Өмнө мөнхийн молор эрдэнэ" үзэсгэлэн 13 дэсийн 13 үзмэр 2026.03.01-03.15-нд: "Монгол төрийн мэргэн сайд Агданбуугийн Амар" үзэсгэлэнд 13 дэсийн 13 үзмэр 2026.03.20-04.07-нд: "Р.Чойном-90 жил" үзэсгэлэнд 2 дэсийн 2 үзмэр 2026.04.05-05.05-нд: "Алс газар сурахаар одогсод-100	100%

					сэтгэл ханамжийн судалгаа хийнэ. Жилийн эцэст: Жилийн эцэст: 1.Хамтарсан 1 тусгай үзэсгэлэн зохион байгуулсан байна. 2.Нийт 60.000 үзэгчдэд үйлчилнэ. 3.Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг 80%-д хүргэнэ.	жил” үзэсгэлэнд 2 дэсийн 2 үзмэр 2026.04.29- 05.07-нд: "Монголчуудын үсэг бичиг, утга соёлын өв" үзэсгэлэнд 29 дэсийн 32 үзмэр 2026.05.12-06.12-нд: "Хутагт Латимор хоёр: Тив дамнасан өв" үзэсгэлэнд 32 дэсийн 49 үзмэр дэглэж "Чингис хаан: Дэлхийг өөрчилсөн нь" гадаад үзэсгэлэнд 33 дэсийн 38 үзмэр оролцуулсан. 2.Түр үзэсгэлэнгийн үеэр үзэгчдийн санал, сэтгэгдлийг бүртгэх зорилгоор санал, сэтгэгдлийн дэвтэр ажиллуулж, мөн цахим хэлбэрээр хэсэгчлэн сэтгэл ханамжийн судалгааг цахим хуудсаар авсан. Нийт 50 үзэгч үзэсгэлэнг “сонирхолтой” хэмээн үнэлсэн байна. Харин 8 үзэгч үзэсгэлэнгийн гэрэлтүүлэг, тайлбарыг сайжруулах талаар санал өгсөн. “Сэтгэл ханамжгүй” буюу “таалагдаагүй” сөрөг үнэлгээ бүртгэгдээгүй бөгөөд түр үзэсгэлэн нь үзэгчдийн дунд өндөр үнэлгээ авсан. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: 1.Байгууллага, хувь хүмүүсийн цуглуулгаар хамтарсан 6 тусгай үзэсгэлэн зохион байгуулсан байна. 2.Үзэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа хийнэ. Хавсралт: 44 файл	
3.2.4	Олон нийтийг соён гэгээрүүлэх, соёлын өвийг таниулах, хамгаалах, сурталчлах зорилгоор хэвлэл	8.000.000 Нэмэлт орлого	1. Телевизийн нэвтрүүлгийн тоо. 2. Видео контентын тоо. 3. Цахим сурталчилгааны төрлийн богино шторк, постерын тоо.	Жил бүр олон нийтэд зориулсан түүх, угсаатны сэдэвтэй танин мэдэхүйн нэвтрүүлгийг	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 1.Музейн үзмэр цуглуулгыг сурталчилсан телевизийн 2 нэвтрүүлэг бэлтгэн олон	1.Телевизийн бие даасан нэвтрүүлгийн тоо - 3. МҮОНТВ-н “Өв соёл” нэвтрүүлэгт 3 цуврал, МОНЦАМЭ мэдээллийн сувгуудаар 7 удаа мэдээлэл нийт 10 цуврал Үйл явдлын мэдээллийг “Монголын мэдээ” - 5 удаа, 25-р суваг ТВ, ТВ-9, NTB, Star TV зэрэг телевизээр 12 удаа хамтран бэлтгэж, олон нийтэд хүргэсэн. 2.Видео контент -15 3.Цахим сурталчилгааны төрлийн богино	100%

	мэдээллийн байгууллагатай хамтран танин мэдэхүйн нийтлэл нэвтрүүлэг, контент, шторк бүтээх.			бэлтгэн түгээдэг.	нийтэд хүргэсэн байна. Жилийн эцэст: Жилийн эцэст: 1. Музейн цуглуулгыг сурталчилсан баримтат өвийн 3 видео контентыг бүтээж, олон нийтэд түгээсэн байна. 2. Соёлын өвийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх цахим сурталчилгааны 3 төрлийн богино шторк, 2 постер хийж цахимаар сурталчилсан байна.	пост -1779 Шторк, рийлс - 201 https://www.facebook.com/nationalmuseummongolia - хандалт - 18.000.239 дагагч, Сарын дундаж хандалт 1,172,013 Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: 1.Музейн үзмэр цуглуулгыг сурталчилсан телевизийн 2 нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд хүргэсэн байна. Хавсралт: 9 файл	
3.3.	Зорилт 3.3. Шинжлэх ухааны суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, үзмэр цуглуулгыг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах,	0	Хэрэгжүүлсэн: Археологийн малтлага судалгааны төсөл, Авран хамгаалах судалгааны ажил, Лавлагаа мэдээлэл, гэрэл зураг	2025 онд зорилтын хүрээнд 2 арга хэмжээ хийж хэрэгжүүлсэн.	Археологийн бие даасан болон хамтарсан малтлага судалгааны төсөл хэрэгжүүлж, археологи, угсаатны зүйн авран хамгаалах	Шинжлэх ухааны суурь судалгааны 1 төсөл хэрэгжүүлж, үзмэр цуглуулгыг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах зорилгоор эрдэм шинжилгээний тодорхойлолт бичиж, лавлагаа мэдээлэл өгч ажилласан.	100%

	лавлагаа мэдээлэл өгөх.				судалгааны ажил гүйцэтгэж, үзмэр цуглуулгыг судалгааны эргэлтэд оруулсан байна.		
3.3.2	Үзмэр цуглуулгыг эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж, үзмэрийн эрдэм шинжилгээний тодорхойлолт бичих, байгууллага, хувь хүмүүсийн хүсэлтээр үзмэр, цуглуулгын лавлагаа мэдээлэл өгөх, гэрэл зураг авхуулах.	0	1. Тодорхойлолт бичигдсэн үзмэрийн тоо, 2. Лавлагаа мэдээлэл өгсөн үзмэр цуглуулгын тоо, 3. Гэрэл зураг авхуулсан үзмэр цуглуулгын тоо	2025 онд 1727 дэсийн 9202 ширхэг үзмэрийн лавлагаа, мэдээлэл өгч эрдэм шинжилгээ судалгааны эргэлтэд оруулсан. Судлаачид, хувь хүмүүсийн хүсэлтээр 127 дэсийн 265 ширхэг үзмэрийн гэрэл зураг авхуулсан.	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Жилийн эцэст: 1. 350 ш үзмэрийн эрдэм шинжилгээний тодорхойлолт бичигдсэн байна. 2. Байгууллага, хувь хүн, судлаачдын хүсэлтийн дагуу үзмэр цуглуулгын мэдээлэл лавлагаа өгнө. 3. Холбогдох дүрэм, журмын дагуу үзмэрийн гэрэл зураг авхуулна.	1. Тодорхойлолт бичигдсэн үзмэрийн тоо - 60 2. Лавлагаа мэдээлэл өгсөн үзмэр цуглуулгын тоо-99 3. Гэрэл зураг авхуулсан үзмэр цуглуулгын тоо-0 Хүрсэн түвшин: -	100%
3.4.	Зорилт 3.4. Эрдэм шинжилгээний цуврал сэтгүүл, каталоги, арга зүйн	58,055,000	Хэвлүүлсэн эрдэм шинжилгээний цуврал сэтгүүл, каталоги, арга зүйн зөвлөмж,	2025 онд зорилтын хүрээнд 3 арга хэмжээ хийж хэрэгжүүлсэн.	Эрдэм шинжилгээний цуврал сэтгүүл, каталоги, арга зүйн зөвлөмж, өгүүллийг хэвлүүлж,	Эрдэм шинжилгээний 3 хуралд оролцон 3 илтгэл хэлэлцүүлж, үр дүнг олон нийтэд хүргэн ажилласан.	100%

	зөвлөмжийг боловсруулан хэвлүүлэх, түгээх, сурталчлах, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх.		өгүүллийн тоо. Хэлэлцүүлсэн илтгэлийн тоо.		илтгэл хэлэлцүүлсэн байна.		
3.4.3	Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх, дотоод, гадаадын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх.	0	1. Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэлийн тоо 2. Эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийн тоо	2025 онд дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд 15 өгүүлэл хэвлүүлсэн.	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Жилийн эцэст: 1. Түүх, археологи, шашин, соёлын өв, музей судлал сэдэвт эрдэм шинжилгээний 10 хуралд илтгэл хэлэлцүүлсэн байна. 2. Музейн ажилтнууд эрдэм шинжилгээний сэтгүүлд 8-аас доошгүй өгүүлэл хэвлүүлсэн байна.	Нийт археологи, түүхийн чиглэлийн эрдэм шинжилгээний 3 хурал, семинарт оролцож, 3 илтгэл хэлэлцүүлж, судалгааны шинэ үр дүнг олон нийтэд хүргэсэн. Үүнд: 1. Айрагийн гозгор дурсгалын он цагийн асуудалд (Хүннү ба хүннүгийн дараах соёлын он цагийн асуудал ЭШ хурал) 2. МҮМ-ийн археологийн судалгаа (Монгол Улсын археологи, антропологийн судалгаа, хадгалалт, хамгаалалтын ирээдүйн чадавхыг бэхжүүлэх нь семинар) 3. Mongolica ба монгол орон (1920-1930-аад он): Антропологич, монгол судлаач Э.Ж.Линдргэний тэмдэглэл дээр (МУИС-ийн ШУС-ийн Түүхийн тэнхимийн ахисан түвшний суралцагсдын эрдэм шинжилгээний хурал) Хүрсэн түвшин: Жилийн эцэст: 1. Түүх, археологи, шашин, соёлын өв, музей судлал сэдэвт эрдэм шинжилгээний 10 хуралд илтгэл хэлэлцүүлсэн байна. 2. Музейн ажилтнууд эрдэм шинжилгээний сэтгүүлд 8-аас доошгүй өгүүлэл хэвлүүлсэн байна. Хавсралт: 4 файл	100%
3.5.	Зорилт 3.5. Төрийн болон	65,151,600	Зохион байгуулсан	2025 онд зорилтын	Төрийн болон орон нутгийн	Төрийн болон орон нутгийн өмчийн музейн ажилтнуудад зориулсан төлөвлөгөөт болон	100%

	орон нутгийн, хувийн өмчийн музейн ажилтнуудад мэргэжил дээшлүүлэх сургалт, семинар, форум зохион байгуулах.		арга зүйн сургалтын тоо, Зөвлөгөө авсан музейн ажилтнуудын тоо.	хүрээнд 3 арга хэмжээ хийж хэрэгжүүлсэн.	өмчийн музейд, байгууллага, хувийн музейн ажилтнуудад зориулсан төлөвлөгөөт болон захиалгат сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.	захиалгат сургалт, хөтөч тайлбарлагч нарт зориулсан Монголын Үндэсний музей тайлбарлах сургалт зохион байгуулж, 124 байгууллагын 907 ажилтанд арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.	
3.5.1	Төрийн болон орон нутгийн өмчийн музейд, байгууллага, хувийн музейн ажилтнуудад арга зүйн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах.	1.000.000 Нэмэлт орлого	Арга зүйн зөвлөгөө авсан төрийн, орон нутгийн өмчийн музей болон байгууллага, хувийн музейн ажилтнуудын тоо.	Төрийн болон орон нутгийн музейн 450-500 ажилтнуудад жилдээ дунджаар 10 удаагийн арга зүйн зөвлөгөө өгдөг.	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Жилийн эцэст: -Төрийн болон орон нутгийн өмчийн музей болон байгууллага, хувийн музейн 600 ажилтанд арга зүйн зөвлөгөө өгч, Музейн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	Төрийн болон орон нутгийн өмчийн музей болон байгууллага, хувийн музейн нийт 124 байгууллагын 907 хүнд 268 удаа арга зүйн зөвлөгөө өгсөн байна. Нийт тоо: Байгууллага: 124 Хүний тоо: 907 Удаа: 268 Хүрсэн түвшин: Жилийн эцэст: -Төрийн болон орон нутгийн өмчийн музей болон байгууллага, хувийн музейн 600 ажилтанд арга зүйн зөвлөгөө өгч, Музейн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана. Хавсралт: 10 файл	100%
3.5.2	Төрийн болон орон нутгийн өмчийн музей, байгууллагын хүсэлтийн дагуу захиалгат	8.000.000 Нэмэлт орлого	1. Зохион байгуулсан захиалгат сургалтын тоо 2. Оролцогчдын тоо 3. Сэтгэл	Төрийн болон орон нутгийн өмчийн музей, байгууллагын музейн албан хүсэлтийн	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 4 сургалтыг зохион байгуулсан байна.	1.2026.03.18-25-ны өдөр “Соёл, урлагийн байгууллагуудын нэгдсэн сургалт”-ыг ССАЖЗЯ-ны захиалгаар “Үзүүллэгийн зохион байгуулалт, Хадгалалт хамгаалалт”, “Сан хөмрөгийн бүртгэл”, “Эрдэм шинжилгээний ажил” сэдэвт сургалт зохион байгуулж, сургалтад 13 байгууллагын 80	100%

	сургалт зохион байгуулах.		ханамжийн түвшин	дагуу жилдээ 8-10 сургалт зохион байгуулдаг.	Жилийн эцэст: Жилийн эцэст: Нийт 8 сургалтыг дангаар болон хамтран зохион байгуулж, 500 оролцогчдыг хамруулна. Сэтгэл ханамжийн судалгаа хийнэ.	гаруй ажилтан хамрагдсан. 2.2026.05.28-ны өдөр “Төвийн бүсийн музейн ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь” цахим сургалтыг зохион байгуулж 80 байгууллагын 230 мэргэжилтэн 180 төхөөрөмжөөс холбогдож хамрагдсан. 3.2026.06.9-10-ны өдөр “Музей, соёлын ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь” сургалтыг Орхон аймгийн СУАЖЗ-ын газар, Орхон аймгийн музейн захиалгаар зохион байгуулж 21 ажилтан хамрагдсан. 4. 2026.06.16-нд “Монголын музейн бодлого, стратеги”, “Соёлын өвийн чиглэлээр хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааны мэдээлэл” төрийн болон орон нутгийн өмчийн музейн 24 захирал, мэргэжилтнүүд оролцов. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: 4 сургалтыг зохион байгуулсан байна. Хавсралт: 32 файл	
3.5.3	Төлөвлөгөөт 2 сургалт зохион байгуулах.	16.151.600 ССАЖЗЯ-ны санхүүжилт	1. Зохион байгуулсан төлөвлөгөөт сургалтын тоо 2. Оролцогчдын тоо 3. Сэтгэл ханамжийн түвшин	Жил бүр 2 төлөвлөгөөт сургалт семинарыг улс, аймгийн музейнхэнд зохион байгуулж, тодорхой сэдвээр хэлэлцүүлэг хийж зөвлөгөө өгдөг.	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Жилийн эцэст: 1. “Музейн ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь” сургалтыг зохион байгуулсан байна. 2. “Музейн үйл ажиллагааг дижиталжуулах	1. “Үзмэртэй харьцах арга зүй” “Музейн ажилтны мэргэжлийн ёс зүй” сургалтыг МҮМ-н шинэ ажилтнуудад зориулан зохион байгуулсан. Нийт 17 ажилтан хамрагдсан. 2. “Төвийн бүсийн музейн ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь” цахим сургалтыг зохион байгуулж 80 байгууллагын 230 мэргэжилтэн 180 төхөөрөмжөөс холбогдож хамрагдсан. Нийт 247 Хүрсэн түвшин: Жилийн эцэст: 1. “Музейн ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь” сургалтыг зохион байгуулсан байна. 2. “Музейн үйл ажиллагааг дижиталжуулах нь” сургалтыг улсын	100%

					нь” сургалтыг улсын хэмжээнд зохион байгуулна. 3. Нийт 200 оролцогчдыг хамруулна. 4. Сэтгэл ханамжийн судалгаа хийнэ.	Хавсралт: 32 файл	
3.5.4	Аялал, жуулчлалын хөтөч тайлбарлагч нарын ур чадварыг сайжруулах сургалтыг зохион байгуулах.	0	1. Сургалтын тоо 2. Оролцогчдын тоо 3. Сэтгэл ханамжийн түвшин	Жил бүр 1-2 удаа зохион байгуулдаг.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 1. Хөтөч тайлбарлагчид МҮМ тайлбарлах ур чадвар, суурь мэдлэг олгох, чадавхжуулах онол-дадлагын сургалтыг зохион байгуулсан байна. 2. МҮМ-г англи хэлээр тайлбарлах сургалт зохион байгуулсан байна. 3. Нийт 65 хөтөч тайлбарлагч нарыг хамруулна. 4. Сэтгэл ханамжийн	1. 2026.04.8-9-нд: “Монголын Үндэсний музейг тайлбарлах” сургалтыг аяллын хөтөч тайлбарлагч нарт тайлбарлах ур чадвар, суурь мэдлэг олгох, чадавхжуулах онол-дадлагын сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 40 хүн хамрагдсан. 2. 2026.04.17-нд: “Монголын Үндэсний музейг англи хэл дээр тайлбарлах” сургалт зохион байгуулсан. Сургалтад 28 хүн хамрагдсан. 3. Нийт 68 хөтөч тайлбарлагч нарт сургалт хийсэн. 4. Сэтгэл ханамжийн судалгаа хийхэд 96 хувийн үнэлгээ авсан. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: 1. Хөтөч тайлбарлагчид МҮМ тайлбарлах ур чадвар, суурь мэдлэг олгох, чадавхжуулах онол-дадлагын сургалтыг зохион байгуулсан байна. 2. МҮМ-г англи хэлээр тайлбарлах сургалт зохион байгуулсан байна. 3. Нийт 65 хөтөч тайлбарлагч нарыг хамруулна. 4. Сэтгэл ханамжийн судалгаа хийсэн.	100%

					судалгаа хийнэ. Жилийн эцэст: -		
3.6.	Зорилт 3.6. Бүх нийтийн соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх, музейн боловсрол, танин мэдэхүйн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх.	68,000,000	Хэрэгжүүлсэн боловсролын хөтөлбөр, хамрагдсан үзэгчдийн тоо, Олон улсын болон дотоодын соёлын арга хэмжээ, оролцсон үзэгчдийн тоо	2025 онд зорилтын хүрээнд 5 арга хэмжээ хийж хэрэгжүүлсэн.	Музейн боловсролын хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, олон улсын болон дотоодын соёлын арга хэмжээнд идэвхтэй оролцоно.	Бүх нийтийн соёлын өвийн боловсролыг дээшлүүлэх, музейн боловсрол, танин мэдэхүйн үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэх зорилгоор Монголын Үндэсний музейн боловсролын хөтөлбөрийн бодлогыг шинээр боловсруулан батлуулж, төлөвлөгөөт ажлыг бүрэн гүйцэтгэлээ.	100%
3.6.1	“Монголын Үндэсний музейн боловсролын хөтөлбөрийн бодлогыг шинэчлэн боловсруулж, Монгол соёлын өвийн бэлгэдэлт дүр “Боролдой хүү” музейн боловсролын шинэ хөтөлбөрийг боловсруулж, зохион байгуулах.	15.000.000 Нэмэлт орлого	1. МҮМ-н боловсролын хөтөлбөрийн бодлогыг шинэчлэн батлуулсан эсэх. 2. “Боролдой хүү” боловсролын хөтөлбөр шинээр боловсруулсан эсэх. 3. Боловсролын хөтөлбөрт хамрагдсан сурагчдын тоо.	2025 онд музейн соёлын үйлчилгээ, зорилтот төсөл, музейн боловсролын 6 хөтөлбөрт 15190 хүүхэд хамрагдсан.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 1. Монголын Үндэсний музейн боловсролын хөтөлбөрийн бодлогыг шинэчлэн боловсруулж, захирлаар батлуулсан байна. 2. “Боролдой хүү” боловсролын хөтөлбөр шинээр боловсруулна. Жилийн эцэст: Жилийн эцэст: 15100	1.Монголын Үндэсний музейн боловсролын хөтөлбөрийн бодлогыг шинэчлэн боловсруулж, байгууллагын захирлаар батлуулсан. Музейн боловсролын хөтөлбөрийн 5 багц: 1."Өвлөн суралцъя!" Сургуулийн өмнөх боловсрол, ЕБС-ийн сурагчдад, 2. "Дижитал музей хөтөлбөр" VR-н 11 төхөөрөмжөөр 12 сэдвийн танин мэдэхүйн хөтөлбөртэй. 3. "Хүртэхүй ба танихуй" тусгай хэрэгцээт үзэгчдийн хөтөлбөр, 4. "Гэр бүлийн хөтөлбөр". Музейн боловсролын хөтөлбөрт тариф тогтоон “Гэрэгэ киоск төхөөрөмж”-д “Боловсролын хөтөлбөр” цэс оруулж үйлчилгээнд нэвтрүүлэв. 2. "Боролдой хүү" - Биет бус өвийг таниулах бүх насныханд зориулсан угсаатны зүйн цуглуулгад түшиглэсэн боловсролын хөтөлбөр боловсруулсан. “Боролдой хүү” боловсролын хөтөлбөрийг уламжлалт өв, соёлыг таниулах эх хэрэглэгдэхүүний судалгааг хийж, бэлтгэх ажлыг эхлүүлсэн.	100%

					сурагчдыг боловсролын хөтөлбөрт хамруулсан байна.	3. Музейн боловсролын сэдэвчилсэн 5 хөтөлбөрийг 68 удаа зохион байгуулж, 4224 хүүхэд хамрагдсан. Хүрсэн түвшин: Монголын Үндэсний музейн боловсролын хөтөлбөрийн бодлогыг шинэчлэн боловсруулж, захирлаар батлуулсан байна. 2. “Боролдой хүү” боловсролын хөтөлбөр шинээр боловсруулав. Хавсралт: 17 файл	
3.6. 2	Харааны бэрхшээлтэй үзэгчдэд зориулан хүрч мэдрэх үзүүлэлтийн булан байгуулж брайль тайлбар байршуулах, хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдэд музейн үйлчилгээг хүргэх.	12.000.00 0 Нэмэлт орлого	1. Брайль тайлбартай танхимын тоо. 2. Танхимаар үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдийн тоо.	Хөгжлийн бэрхшээлтэй 252 үзэгчид музейн үйлчилгээнд хамрагдсан.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: Музейн байнгын үзүүлэлтийн танхимд хүрэлцэх боломжтой орчин бүрдүүлж, холбогдох үзүүлэлтийн брайль тайлбар байрлуулж, музейн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. Жилийн эцэст: Жилийн эцэст: “Музей үзэх гоё” арга хэмжээг хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдэд зохион	1. Байнгын үзүүлэлтийн 9 танхимын ерөнхий тайлбарын брайл танилцуулгаар үзэгчдэд үйлчилж байна. 2. Танхимаар үйлчлүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй үзэгчдийн тоо -188. Хүрсэн түвшин: Музейн байнгын үзүүлэлтийн танхимд хүрэлцэх боломжтой орчин бүрдүүлж, холбогдох үзүүлэлтийн брайль тайлбар байрлуулж, музейн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. Хавсралт: 4 файл	100%

					байгуулж, танхимаар 300 үзэгчдэд үйлчилж, соёлын тэгш хүртээмжтэй үйлчилгээ үзүүлнэ.		
3.6.3	Соёлын өвийн ашиглалтын олон хэлбэрийг хөгжүүлэх хүрээнд “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээг зохион байгуулах.	0	1. “Музейн нээлттэй өдрүүд-2026”-ээр үйлчлүүлсэн үзэгчдийн тоо 2. Сэтгэл ханамжийн түвшин	Жил бүрийн III сард тогтмол зохион байгуулагддаг.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: “Музейн нээлттэй өдрүүд-2026” арга хэмжээг зохион байгуулж, 12.000 хүнд үйлчилж, музейн үзэгчдийн тоог нэмэгдүүлнэ. Жилийн эцэст: -	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 96 дугаар тогтоол, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйл, 109 дүгээр зүйлийн 109.4 дэх хэсэг, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 15/527 дугаар албан бичиг, “Музейн нээлттэй өдрүүд-2026” арга хэмжээний удирдамжийг үндэслэн Захирлын 2026.02.28-ны А/13 тоот тушаалаар “Музейн нээлттэй өдрүүд-2026” арга хэмжээг 2026.03.01-07-ны өдрүүдэд 7 өдрийн турш 18 төрлийн хөтөлбөртэй зохион байгуулж, 33.012 үзэгчдэд үйлчлэв. Үүнд: 0-16 насны хүүхэд - 11.473, Оюутан залуус - 13.794, Насанд хүрэгсэд - 5625, Ахмад настан - 1.133, Тусгай хэрэгцээт иргэн - 225, Гэр бүл - 1.736, Жуулчин - 159 Боловсролын хөтөлбөрт 1765 хүн хамрагдсан. 2. Сэтгэл ханамжийн түвшин -100%-тай. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: “Музейн нээлттэй өдрүүд-2026” арга хэмжээг зохион байгуулж, 33.012 хүнд үйлчилж, музейн үзэгчдийн тоог нэмэгдүүлэв. Хавсралт: 12 файл	100%
3.6.5	“Олон улсын музейн өдөр”-	31.000.000	1. Зохион байгуулсан	Жил бүр олон нийтэд	Эхний хагас жилд: Эхний	1.“Олон улсын музейн өдөр” арга хэмжээг ССАЖЗЯ, СУИС-ийн Соёл, урлаг судлалын	100%

	т зориулсан арга хэмжээг зохион байгуулах.	ССАЖЗЯ-ны санхүүжилт	арга хэмжээний тоо 2. Оролцсон үзэгчдийн тоо 3. Хэрэгжүүлсэн боловсролын хөтөлбөрийн тоо 4. Оролцсон хүүхдүүдийн тоо	нээлттэй зохион байгуулдаг.	хагас жилд: “Олон улсын музейн өдөр” арга хэмжээг ICOM Mongolia”-тай хамтран зохион байгуулна. 1. “Музейн судалгаа-2026” Эрдэм шинжилгээний хурал 2. “Хуваагдмал дэлхийг нэгтгэж буй музейнүүд” сэдвийн хүрээнд олон нийтэд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулсан байна. 3. 3 боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ. 4. 300 хүүхдүүдэд үйлчилнэ. Жилийн эцэст: -	хүрээлэн, ОУМЗ-ийн Монголын үндэсний хороо, Чингис хаан үндэсний музей, Байгалийн шинжлэх ухааны үндэсний музей, Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейтэй хамтран “Музейн судалгаа: Хуваагдмал дэлхийг нэгтгэж буй музейнүүд” Эрдэм шинжилгээний хурлын ерөнхий зохион байгуулалтыг хариуцаж төлөвлөгөө, ажлын хуваарилалт, оролцогчдын бүртгэл, урилга тараах нэрс, хэвлэлийн мэдээг бэлтгэж хэвлэл мэдээлэлд зар түгээж, хурлын бүтэн бичлэг хийж, зураг авсан. Хуралд нийт 24 илтгэл хэлэлцүүлж, 44 байгууллагын 200 гаруй хүн оролцсон бөгөөд 43 хуудас хурлын тэмдэглэл, 83 хуудас тайлан бичиж ССАЖЗЯ болон Соёл урлаг судлалын хүрээлэн рүү илгээсэн. 2.“Хуваагдмал дэлхийг нэгтгэж буй музейнүүд” сэдвийн хүрээнд олон нийтэд зориулсан “Олон улсын музейн өдөр” 2 дугаар ЕБС, “Үй цай” Олон улсын дунд сургууль, 73 дугаар ЕБС-ийн сурагчид музей үзэж танилцсан. 3. Нийт 300 сурагчид “Дижитал музей” боловсролын хөтөлбөрт хамрагдсан. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: “Олон улсын музейн өдөр” арга хэмжээг ICOM Mongolia”-тай хамтран зохион байгуулна. 1. “Музейн судалгаа-2026” Эрдэм шинжилгээний хурал 2. “Хуваагдмал дэлхийг нэгтгэж буй музейнүүд” сэдвийн хүрээнд олон нийтэд зориулсан үйл ажиллагаа зохион байгуулсан байна. 3. 3 боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ. 4. 300 хүүхдүүдэд үйлчилнэ.	
--	--	----------------------	--	-----------------------------	---	--	--

						Хавсралт: 11 файл	
3.7.	Зорилт 3.7. Эрдэм шинжилгээ судалгаа, музейн үйл ажиллагааны чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх.	0	Хэрэгжсэн төсөл хөтөлбөрийн тоо, Бүтээл, контентын тоо, Хамрагдсан ажилтнуудын тоо	2025 онд зорилтын хүрээнд 2 арга хэмжээ хийж хэрэгжүүлсэн.	Олон улсын соёлын хамтарсан төсөл хөтөлбөр хэрэгжүүлсэн байна.	Эрдэм шинжилгээ судалгаа, музейн үйл ажиллагааны чиглэлээр гадаадын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилтын хүрээнд БНСУ, Япон улсын эрдэм шинжилгээний байгууллагатай хамтарсан 2 судалгааны төсөл хэрэгжүүлж байна.	100%
3.7. 1	“Монгол Улсын соёлын үнэт зүйлсийн дижитал удирдлагын системийг бүтээх, соёлын контент бүтээх чадавх бэхжүүлэх” төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх.	0	1. Хамтран бүтээсэн аудио контент, видео контентын хэлбэр, тоо. 2. Чадавх бэхжүүлэх танхимын болон цахим сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо.	Шинэ төсөл	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Жилийн эцэст: БНСУ-ын Азийн соёлын төв, Жоннамын Их сургуулийн төслийн багтай хамтран 8 аудио контент 3 хэлээр, 1 видео контент бүтээж, төслийн багийн ажилтнууд чадавх бэхжүүлэх танхимын болон цахим сургалтад хамрагдсан байна.	БНСУ-ын Азийн соёлын төв, Жоннамын Их сургуулийн төслийн багийн гишүүдтэй цахим уулзалт хурлыг 3 удаа зохион байгуулж төслийн 2026 оны төлөвлөгөө, сургалтын хуваарь, хамрагдах ажилтны мэдээллийг хэлэлцэж баталгаажуулсан. "Mongolia Cultural Heritage Management System & Historical Documents Management System Development Plan" -ыг ССАЖЗЯ-ны удирдлагын түвшинд хэлэлцэн тохирсон. Монголын Үндэсний музейд 8 аудио контент 3 хэлээр, 1 видео контентын судалгаа, эх бичвэрийг бэлтгэсэн. Хүрсэн түвшин: Төслийн ажлын 2026 оны төлөвлөгөө, сургалтын хуваарь батлагдсан. Хавсралт: 4 файл	100%
3.7. 2	Япон улсын “Тал нутгийн	0	1. Хоёр тал гарын үсэг	Шинэ төсөл	Эхний хагас жилд: Эхний	Япон Улсын Тал нутгийн археологийн нийгэмлэгтэй 2026 оны 05 сарын 28-ны	100%

	археологийн холбоо"-той хамтран музейн сан хөмрөгийн хүрлийн үеийн зарим үзмэрт гурван хэмжээст мэдээлэл хийх, хамтарсан судалгаа хийх төслийг хэрэгжүүлэх.		зурж баталгаажсан төслийн гэрээ. 2. Судалгааны явцын тайлан		хагас жилд: Төслийн гэрээг байгуулсан байна. Жилийн эцэст: Жилийн эцэст: "Монгол нутаг дахь археологийн судалгаагаар илэрсэн хүрэл олдворын гурван хэмжээст мэдээлэлд дүн шинжилгээ хийх судалгаа" -г эхлүүлсэн байна.	өдөр 29-19 дугаартай гэрээ байгуулсан. "Монгол нутаг дахь археологийн судалгаагаар илэрсэн хүрэл олдворын гурван хэмжээст мэдээлэлд дүн шинжилгээ хийх судалгаа"-ны гэрээ байгуулж 14 дэсийн 14 үзмэрийн хэмжилт судалгааг хийсэн. Хүрсэн түвшин: Эхний хагас жилд: Төслийн гэрээг байгуулсан байна. Хавсралт: 8 файл	
Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ							
4.1.	Зорилт 4.1. Байгууллагын бодлого төлөвлөлт, хүний нөөцийн үйл ажиллагааг сайжруулах	133,000,000	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Хамрагдсан ажилтнуудын тоо	2025 онд зорилтын хүрээнд 5 арга хэмжээ хэрэгжүүлсэн.	Байгууллагын санхүү, хүний нөөц, дотоод үйл ажиллагааг сайжруулан ажиллана.	Байгууллагын санхүү, хүний нөөцийн бодлогыг сайжруулах, нийгмийн баталгааг хангах чиглэлээр эхний хагас жил төлөвлөсөн ажлуудыг бүрэн гүйцэтгэж ажиллалаа.	100%
4.1. 3	Байгууллагын үйл ажиллагааны орлогыг нэмэгдүүлэх.	0	1. Байгууллагын үйл ажиллагааны орлогын тоо хэмжээ. 2. Түүний байгууллагын төсөвт харьцуулсан	2025 онд 955,089,705.17 төгрөгийн орлого төвлөрүүлсэн .	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: 300,000,000 төгрөг төвлөрүүлнэ. Жилийн эцэст: 1. Сүүлийн хагас жил 800,000,000	2026 оны 06 сарын 18-ны өдрийн байдлаар 220,600,500 төгрөгийн орлого төвлөрүүлээд байна. Хүрсэн түвшин: 300,000,000 Хавсралт: 1 файл	90%

			хувь хэмжээ.		төгрөг, Нийт 1,100,000,000 төгрөгийн орлого төвлөрүүлнэ. 2. Байгууллагын төсвийн 61%- тай тэнцэх орлого бүрдүүлж ажиллана.		
4.1. 4	Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хүрээнд “Эрүүл мэндийн багц үзлэг”-т хамруулах.	108.200.0 00 Нэмэлт орлого	1. Эрүүл мэндийн багц үзлэгт хамрагдсан ажилтнуудын тоо 2. Сэтгэл ханамжийн түвшин 3. Зарцуулсан зардлын тооцоо	Шинэ ажил	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Жилийн эцэст: Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлж, нийт ажилтнуудыг эрүүл мэндийн багц үзлэгт 100 хувь хамруулснаар ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого хэрэгжүүлнэ.	1. МҮМ-н Захирлын А/28 дугаар тушаалаар 45 ажилтанд нийт 180,450,000 төгрөгийн мөнгөн урамшуулал олгосон. 2. МҮМ-н Захирлын А/31 дүгээр тушаалаар 3 ажилтанд нийт 5,000,000 төгрөгийн ахисан шатны сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлсэн. 3. МҮМ-н Захирлын А/32 дугаар тушаалаар 9 ажилтанд нийт 18,000,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн. Хүрсэн түвшин: Жилийн эцэст: Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлж, нийт ажилтнуудыг эрүүл мэндийн багц үзлэгт 100 хувь хамруулснаар ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлого хэрэгжүүлнэ. Хавсралт: 3 файл	100%
4.1. 5	Авлигатай тэмцэх хууль, Авлигатай тэмцэх үндэсний	4.000.000 Нэмэлт орлого	Авлигын соён гэгээрүүлэх зорилгоор зохион байгуулсан	2025 онд “Авлигаас урьдчилан сэргийлэх нь” сэдэвт 1	Эхний хагас жилд: - Жилийн эцэст: Жилийн эцэст: Авлигын хор	1. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны чиглэлээрх ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг байгууллагын 2026 оны нэмэлт төсвөөс 4.000.000 төгрөгийг	100%

	хөтөлбөрийн хүрээнд ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах, боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэх.		арга хэмжээний тоо, зарцуулсан зардлын тооцоо.	сургалтыг 48 ажилтны дунд зохион байгуулсан.	уршгийг харуулсан түүхэн баримт, ёс зүй, түүхэн сургамжийг өгүүлсэн “Авлигын эсрэг соёл” соён гэгээрүүлэх ажил зохион байгуулсан байна.	тусгуулж, байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан. 2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон Шилэн дансны тухай хуулийн хүрээнд хөндлөнгийн хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэн, шилэн дансны нэгдсэн цахим систем www.shilendans.gov.mn нийт 06-р сарын 18-ны байдлаар 71 мэдээлэл хугацаанд нь байршуулсан. Хүрсэн түвшин: Жилийн эцэст: Авлигын хор уршгийг харуулсан түүхэн баримт, ёс зүй, түүхэн сургамжийг өгүүлсэн “Авлигын эсрэг соёл” соён гэгээрүүлэх ажил зохион байгуулсан байна. Хавсралт: 1 файл	
4.1.6	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, байгууллагын ил тод байдлын хэрэгжилтийг хангах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг тайлагнах.	0	Цахимжсан албан хэрэг хөтлөлтийн тоо, төрөл.	2025 онд бэлтгэл ажлыг ханган ажилласан.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: Албан хэрэг хөтлөлт, судалгаа мэдээлэл, статистик тоон мэдээлэл, албан бичиг, цаг бүртгэлийг цахим системээр хөтлөн тогтмолжуулсан байна. Жилийн эцэст: Жилийн эцэст: Байгууллагын албан хэрэг	Байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр гаргасан захирлын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 16-ны хооронд А тушаал 68, хүний нөөцийн чиглэлээр Б тушаал 62, гадна байгууллагад явуулсан 113 албан бичиг болох удирдлагын үйл ажиллагааны явцад хөтлөгдөх баримт бичгийг MNS 5140-2:2021, MNS 6395:2022 стандартуудад заасан баримт бичгийн бүрдэл, тавигдах шаардлагын дагуу хос бичгээр хөтлөн явуулж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Манай байгууллагад албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн программ (https://erp.e-mongolia.mn/home) систем буюу цахим хаягаар ирүүлсэн 61, цаасаар ирүүлсэн 52 албан бичгийг хүлээн авч захирал болон нэгжийн дарга нарт танилцуулан цохолт хийлгэн холбогдох мэргэжилтэн, албан хаагчдаар шийдвэрлүүлж ажиллаж байна.	100%

					бүрэн цахимжсан байна.	Байгууллагын захирамжлалын болон зохион байгуулалт, мэдээлэл лавлагааны баримт бичгийн бүртгэлийг шинэчлэн батлагдсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын хавсралтад зааснаар хөтлүүлж хэвшсэн. Хүрсэн түвшин: Албан хэрэг хөтлөлт, судалгаа мэдээлэл, статистик тоон мэдээлэл, албан бичиг, цаг бүртгэлийг цахим системээр хөтлөн тогтмолжуулсан.	
4.1. 7	Байгууллагын гадаад, дотоод харилцааг өргөжүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх.	0	Бусад байгууллагатай байгуулсан гэрээ хэлэлцээр, санамж бичгийн тоо.	5 байгууллагатай хамтын ажиллагаа шинээр эхлүүлсэн.	Эхний хагас жилд: Эхний хагас жилд: Байгууллага хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлж хамтын ажиллагааны гэрээ байгуулсан байна. Жилийн эцэст: Жилийн эцэст: Музейн гадаад харилцааг идэвхжүүлж, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр, санамж бичиг байгуулсан байна.	Монголын Үндэсний музейгээс аж ахуйн нэгж, иргэнтэй хамтран ажиллах 25 гэрээ, ваучерын 48 гэрээг байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Санамж бичгийн тоо - 6: Архивын ерөнхий газар, МУИС-ийн Нүүдэлчдийн археологийн хүрээлэн, Монголын галлерейн холбоо, Үндэсний мэдээллийн Монцамэ, Дүрслэх урлаг технологийн сургууль, ШУА-ийн Археологийн хүрээлэн зэрэг 6 байгууллагатай санамж бичиг байгуулж, хамтын ажиллагааг өргөжүүлэн ажиллаж байна. Хүрсэн түвшин: Музейн гадаад харилцааг идэвхжүүлж, хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр, санамж бичиг байгуулсан. Хавсралт: 9 файл	100%

Үнэлсэн:

..... /...../

(албан тушаал)

(гарын үсэг)

.....

(огноо)

Тайлагнасан:

..... /...../

(албан тушаал)

(гарын үсэг)

.....

(огноо)